Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Байгалийн ухааны багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн / биологи, эрүүл мэнд /, Намшир Болорцэцэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх. | | | | | | | |
| 1 | Ментор багш нарыг бэлтгэж, Ментор хөтөлбөр хэрэгжүүлэх. | Бэлтгэсэн ментор багшийн тоо, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 33 (багш), 80 (хувь) | Эхний хагас жилд: - | 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлж буй "Менторшип хөтөлбөр"-ийн үргэлжлэл 25 Ментор багш бэлтгэх хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд хөтөлбөр боловсруулах эхний зураглал гарч сургалтын агуулгын зураглал боловсруулж байна. Үндэсний "Ментор багш бэлтгэх хөтөлбөр"-т хамрагдах зорилтот бүлгийн судалгаа хийх ажил эхэлсэн. Уг хөтөлбөрийг 9 дүгээр сард боловсруулж дуусган багш бэлтгэх сургалт 2025 оны 10 дугаар сард эхлүүлэхээр төлөвлөж байна. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Ерөнхий боловсролын | Дүрэм, журмын | 950 удирдах | 2 | 2025 оны 04 дүгээр сарын 18- | 2-р сар, 3-р | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах | хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, батлагдсан удирдамж, тайлан | ажилтан | | ны өдөр Боловсролын ерөнхий газрын даргын баталсан "Ерөнхий боловсролын сургуулиудын багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах" сургалтын удирдамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 23- 30-ны өдөр Сүхбаатар аймгийн 21 удирдах ажилтан, Хэнтий аймгийн 33 багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтаас менежерүүд олон талын шинэ санааг авч чадсан, хоорондоо сайн туршлагаа хуваалцсан үр дүнтэй сургалт болсон. Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22 ны А/25 тоот тушаалаар баталсан Багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны журамд заасан "Багшийг дадлагажуулах" үйл ажиллагааны жишиг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг ахлан ажиллаа.Жишиг хөтөлбөрийг боловсруулахдаа БАБХГ-ын мэргэжилтнүүд, Багшийн хөгжлийн дэмжих үндэсний төвийн санал, шүүмжийг тусгахын зэрэгцээ ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийн | сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саналыг тусгалаа.Мөн Кембрижийн ментор үйл ажиллагааны хөтөлбөрийг судаллаа.Ажлын хэсэг жишиг хөтөлбөрийг 2 удаа хэлэлцүүлж, Боловсролын ерөнхий газрын даргаар батлуулан сургалтын байгууллагуудад албан бичгээр хүргүүллээ.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3 | Биологи, эрүүл мэндийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих үндсэн сургалт зохион байгуулах | Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө, оролцогчдын тоо, хувь | 177 багш, 87% | 88% | Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт Хоёрдугаар хавсралт Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий болосролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг баг хамт олны хамт хийж гүйцэтгэсэн. Мөн ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг "Эргэцүүлэлт суурилсан багшийн хөгжил", " Багшийн цахим ур чадвар", " Хичээлийн ёудалгааны арга зүй" зэрэг гурван үндсэн агуулгын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 03-04 ны өдөрТөв аймгийн 120 багшид, 04 дүгээр сарын 07-08 ны өдөр Баянзүрх дүүргийн 381 багш нарт зохион байгуулахад чиглүүлэгч багшаар ажилласан. Сургалтын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | онцлог нь танхимд 5,10,15,20 жилийн багш нар хамт сууж суралцан бие биедээ сайн туршлагаа түгээж, хамтран бүтээж олон төрлийн дадлага ажлыг багаар хамтран гүйцэтгэж бие биенээсээ урам авсан багш нарын хэрэгцээ, сонирхолд нийцсэн, туршлагаа хуваалцсан үр дүнтэй сургалт болсон. Биологи, эрүүл мэндийн багш нарын танхимын бус сургалт 04 дүгээр сарын 14-ний өдрөөс болон 05 дугаар сарын 09 - ний өдөр цахим хэлбэрээр Bagsh.edu.mn платформ дээр зохион байгуулсан. Танхимын сургалтын явцад суралцсан агуулга, арга, аргачлалаа ажлын байран дээрээ хэрэгжүүлэн өөрийн арга зүйгээ сайжруулж, ахиц гаргаж байгаа олон багш нар байна. Мөн багаар ажиллах чадварт багш нар сайн суралцсан бас суралцаж байгаа нь гэрийн даалгаврын гүйцэтгэлээс харагдаж байсан. Цахим ур чадвараа ахиулах хиймэл оюун ухаан болон бусад платформ, APP -ийг чадварлагаар ашиглаж хичээлээ бэлдсэн байна. Өөрийн ажлаа өдөр дутамдаа эргэцүүлэх чадарт суралцсан. Танхимын сургалтад багш нар идэвхтэй оролцоотой байсан ч цахимын сургалтын үед зарим багш нар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | идэвхгүй оролцох мөн аргацаагаад өнгөрөх хандлага ажиглагдсан. Учир нь тэр багш нарын илгээсэн даалгавар чанаргүй, гүйцэтгэл хангалтгүй байсан. Танхим, цахим ямар ч хэлбэрийн сургалтаас суралцах чадварт илүү өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ байна. Хавсралт: 24 файл | | |
| 4 | Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэх. | Цахим сургалтын тоо, гүйцэтгэлийн хувь | 0 | 12 (сургалт), 50 (хувь) | Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газраас сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан өөрсдийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломж бий болгох зорилт тавин ажиллаж байна.Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформд суурилан суралцах боломжтой болж байна.Боловсролын ерөнхий газраас 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулсан модуль сургалтын үр дүнгийн судалгаа, мониторингоос багш нараас хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг сонгож, боловсруулсан багтай гэрээ байгуулан БЕГ-ын өмчид авсан.Манай байгууллага гэрээний дагуу тус 12 модулийг ашиглан сургалт зохион байгуулах эрхтэй. Багшийн хөгжлийн Bagsh.edu.mn | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | платформд 12 модулийг байршуулсан бөгөөд багш нар сонголтоороо үнэ төлбөргүй судалж, амжилттай төгсвөл батламж авах боломжийг бүрдүүллээ. Bagsh.edu.mn платформ байршуулсан 12 модуль сургалтын жагсаалтыг хавсралтаар байршуулсан. 2. Биологи, эрүүл мэндийн багш нарт зориулан 10 дэд агуулга бүхий "Жендерийн тухай ойлголт" модулыг байршуулж судлуулсан. Хавсралт: 11 файл | | |
| 5 | Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх | Оролцогчдын тоо, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 20 (оролцогч), 100 (хувь) | - | - | 1-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 0% |
| 6 | Биологи судлагдахууны багшид “Зөвлөх” мэргэшлийн зэрэг олгох дүгнэлт гаргах. | Гүйцэтгэлийн хувь | 100 | 50 | Ховд аймаг, Өвөрхангай аймгийн политехникийн коллежийн биологи, эрүүл мэндийн 2 багшийн тэргүүлэх зэргийн материал уншиж дүгнэлт гаргасан. Хавсралт: 1 файл | 1-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 7 | Сургалтын байгууллагын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн | Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, МХБ-ийн сайн туршлагын тоо | 60 (МХБ-ийн тоо), 45 (сайн туршлагын тоо | 116 (МХБ-ийн тоо), 25 (сайн туршлагын тоо) | Боловсрол шинжлэх ухааны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Мэргэжлийн багш | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | туслах, үндэсний хэмжээнд онол практикийн бага хурал зохион байгуулж, сайн туршлага бүхий МХБ-ийн сан бүрдүүлэх. | | | | нарын бүлгийн үйл ажиллагаа"-ны хүрээнд ерөнхий боловсролын 156 сургуулиас мэргэжлийн багшийн бүлгийн үйл ажиллагааны үр дүнг асуулгаар авахад багшийн хөгжлийн төвтэй сургууль 141, төвгүй 15 сургууль байна. Багшийн хөгжлийн төлөвлөгөөний 60 орчим хувийг мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа эзэлж байна. Сургуульд дунджаар 5 мэргэжлийн багш нарын бүлэг ажиллаж, бүх багш нар хамрагддаг болсон. Мэргэжлийн багш нарын бүлгээр ажиллахад танд болон багш нарт гарч буй асуудал. Бүлгийн төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бусад ажлуудтай давхцдаг, багаар ажиллах чадвар сул, сургуулийн ажил болон хичээлд бэлтгэх цаг их, аливаа уралдаан тэмцээн зохион байгуулахад санхүү хэцүү, хамтран ажиллахад цаг хугацаагаа тааруулахад хүндрэлтэй, өглөө, өдрийн ээлжийн хичээлээс шалтгаалаад, зарим тохиолдолд төлөвлөсөн ажлыг явуулах үед гаднаас гэнэт төлөвлөгдөөгүй ажил гарч ирж багш нарт ажлын ачаалал үүсдэг. Сурагчдын тоо цөөн тул мэргэжил бүрийн багшийн тоо цөөн Цаашид багшийн хөгжлийг | сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжих чиглэлээр сургууль болон багш нарт дараах дэмжлэг хэрэгтэй байна. Залуу багш нарыг дагалдуулан, дадлагажуулан сургахад Зөвлөх багш нарын хүч, нөөцийг дайчлах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх. Мэдээллийн технологийн сургалтад дунд болон ахмад үеийн багш нарыг суулгаж чадавхжуулах. Анги танхимд сургалтын сүүлийн үеийн шинэлэг орчин бүрдүүлэхэд санхүүгийн болон орчин үеийн сургалтын тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх. Боловсролын газраас багш нарт судлагдахуун бүрээр болон бусад хэлбэрээр хөгжих боломжийг хангалттай сайн олгодог. Багш хөгжлийн тусдаа өрөө, багш нарын хүүхэд байх боломжтой өрөө, хичээлийн байрны асуудал чухал байна. - Тэгш хамран сургах боловсролын мэргэжлийн бүлгийн уулзалт, хэлэлцүүлэгт нэг баг хариуцан ажиллаж чиглүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | | |
| 8 | Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд гадаад улсын Боловсролын газартай туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах. | Судалсан туршлагын тоо | - | 1 | 2025 оны 1 дүгээр сарын 11-19 -ний өдрүүдэд миний бие Өмнөд Солонгос улсад байгалийн шинжлэх ухааны музей үзэх, боловсролын технологийн үзэсгэлэн, сургалт, туршлага судлах үйл | 1-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаанд оролцсон. Дараагийн үйл ажиллагаанд 2025 оны 03 дугаар сарын 24 -ний өдрөөс 04 дгээр сарын 02-ны өдөр нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн биологи, эрүүл мэндийн зөвлөх багш С.Соёлмаа, Өвөрхангай аймгийн биологи, эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Б. Гомбасүрэн нарыг оролцуулан туршлага судлуулсан.<br>Хавсралт: 10 файл | сар | |
| 9 | Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах. | Сургалтад оролцогчдын тоо, хамрагдалтын хувь | - | 650 | 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Боловсролын ерөнхий газрын даргын баталсан "Ерөнхий боловсролын сургуулиудын багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах" сургалтын удирдамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 23- 30-ны өдөр Сүхбаатар аймгийн 21 удирдах ажилтан, Хэнтий аймгийн 33 багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтаас менежерүүд олон талын шинэ санааг авч чадсан, хоорондоо сайн туршлагаа хуваалцсан үр дүнтэй сургалт болсон. Сургалтаар: Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, 2025 | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн А/25 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтыг танилцуулг, Идэвхтэй сургалтын арга зүй, багшлахуй, суралцахуй зэрэг агуулгыг судлан, туршлагаа хуваалцсан, бусдаасаа суралцсан хоёр өдрийн турш идэвхтэй оролцоо сайн байсан. Хавсралт: 5 файл | | |
| 10 | ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа, төсөлт хөтөлбөр) ажлыг зохион байгуулах. | Зохион байгуулсан ажлын тоо, хамрагдалтын хувь | 1 төсөл хөтөлбөр | 1 | 1. Төвийн бүсийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнийг УИХ-ын байнгын хороо, Боловсролын ерөнхий газар хамтран 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр 13:00- 17:30 цагт төрийн ордны их танхимд зохион байгуулсан. Сургалт, зөвлөгөөнд Дархан-Уул аймгаас-77, Төв аймгаас-136, Сэлэнгэ аймгаас 147, улаанбаатар хотоос холбогдох байгууллагаас 40 нийт 400 оролцогч хамрагдсан. Зөвлөгөөнөөр: - Боловсрол, шинжлэх ухааны салбарын шинэчлэл - Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл - Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өнөөгийн байдал, цаашид сайжруулах зарим асуудал, боловсролын багц хуулийн хэрэгжилтийг дэмжих, болон зохион байгуулсан ажлуудын танилцуулга, мөн хэлэлцүүлэг өрнөсөн. 2. "Монгол улсын багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг ногоон болон дижитал шилжилт рүү шинэчлэн нэвтрүүлэх нь" (RETEACH) төслийн эхний жилийн төлөвлөгөөний дагуу анхны уулзалтаар ажлын төлөвлөгөөний танилцуулга болон хуваарилалтыг танилцуулж үүрэг оролцоотой хариуцлагатай байхыг анхааруулж ярилцсан. Багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо, сургалтын бодлого, өнөөгийн нөхцөл байдал судалгааны арга зүйн тайлан боловсруулах ажил дээр багийн гишүүдийн хамт ажилласан. Багш нарыг ажилд авах, ажиллуулах, үнэлгээ, аттестатчилал, түүний шалгуур үзүүлэлтүүд, мэргэжлийн тасралтгүй өсөлтийг хангах албан ба албан бус сургалтын тогтолцоо гэсэн агуулгын хүрээнд боловсруулах ажилд оролцсон. Мөн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд ажиллаж буй багш нарыг ажилд авах, ажиллуулахад холбогдох | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрх зүйн баримт бичиг дээр судалгааны тайлан боловсруулахад мэдээлэл бэлдэж, англи хэл дээр орчуулж бэлдэн хамтран ажилласан. 3. Ерөнхий боловсролын сургуулийн лабораторийн менежментийг сургалтад нийслэлийн 88 багшийг танхимаар орон нутгийн 400 багшийн оглайнаар сургалтад хамруулсан. Биологийн туршилтын гарын авлгын хянагчаар ажилласан. Хавсралт: 17 файл | | |
| 11 | Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах. | Сургалтад оролцогчдын тоо, хамрагдалтын хувь | Сургалт-2, оролцогч-128 | 50% | 2025 оны 2 дугаар сарын 05 -ны өдөр биологи, эрүүл мэндийн судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүдийн туршлага солилцох уулзалт зохион байгуулж мэргэжлийн багш нарын бүлгээр ажиллаж байгаа явц, мэргэжилтнүүдийн чиглүүлэг болон аргачлалын дагуу ажиллаж байгаа сайн туршлагаа бусдадаа түгээн дэлгэрүүлсэн. Танилцуулга мэдээллийн үр дүнд Ховд, Өвөрхангай, Хэнтий, Сэлэнгэ, Дундговь, Дорнод, Сэлэнгэ, Баян-Өлгий, Дархан-уул, Төв аймгууд мэргэжлийн бүлгээр сайн ажиллаж байна. Боловсрол шинэжлэх ухааны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хавсралт болох мэргэжлий багш нарынн бүлгээр ажиллах үйл ажиллагааны заалтуудыг сайтар судлан багш нартаа зөвлөх, дэмжин ажиллахыг зөвлөсөн. Учир нь шинээр ажилд орсон мэргэжилтнүүд байгаа тул мэргэжлийн бүлгийн ажлаа сайн чиглүүлж амжаагүй байсан. Цаашид мэргэжлийн багш нарын бүлгийн ажлынг сайжруулах, шинэ санааг эрэлхийлэх, асуудалд суурилсан бүлгийг журмын дагуу хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Хавсралт: 4 файл | | |
| 3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах | | | | | | | |
| 12 | Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | Биелэлт /хувь/ | 100% | 100 | Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллан цаг үеийн болон хуваарьт сургалт хурал уулзалтад хоцролт, таслалтгүй хамрагдсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон | Биелэлт /хувь/ | 2 | - | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хадгалуулах | | | | урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажилласан. | | |
| 14 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх | Биелэлт /хувь/ | 100% | 100 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг судлан хэрэгжүүлсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | - БЕГ-ын хүний нөөцийг чадавхижуулах ээлжит сургалт болох "Нийгмийн даатгалын шинэчлэл" сургалтад 2025 оны 05 сарын 19-ны өдөр хамрагдаж нэмэлт өөрчлөлт шинэчлэл, зорилго зориулалт, аргачлалын талаар мэдлэг мэдээлэлтэй боллоо. - Олон улсад хүлээн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх /6-12 анги/- үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 02 дугаар сарын 10-11-ний хооронд суралцсан. - Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийг чадавхжуулах сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 12-14ны өдөр сургалтад хамрагдсан - Цахим ур чадвраа ахиулсан мөн AI дээр ажиллах чадвараараа нэмэгдүүлсэн. Монгол бичгийн хичээлийн Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар тавигддаг хичээлээс суралцаж байна. - https://surgalt.gov.mn/academy/#/lms/participant сургалтын талбар дээр монгол бичгийн хичээл судалж байна.<br>Хавсралт: 1 файл | сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 2 | Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах | Батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судална | 7 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр судалсан | Холбогдох шинээр батлагдсан бичиг баримтын сан үүсгэж, уншин судалж, ажилдаа тусгана. | Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22 -ны өдөр батлагдсан А/25 , Боловсролын ерөнхий хууль, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/115, Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/95, Багшийн хөгжлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Байгалийн ухааны багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн / биологи, эрүүл мэнд /, Намшир Болорцэцэг
/................................................./                         Огноо: .........................